

ҮСХ-ны даргын 2015 оны 1 дүгээр сарын 30-
ны өдрийн А/12 тоот тушаалын I хавсралт



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

**Улаанбаатар хот
2015 он**

ГАРЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийн ойлголт, нэр томъёоны тодорхойлолт

Гурав. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт тооцох бүтээгдэхүүн, ашиглах ангилал, норм, итгэлцүүр, мэдээлэл гаргах давтамж, мэдээллийн эх үүсвэр

- 3.1 Үндсэн үзүүлэлт
- 3.2 Ашиглах ангилал
- 3.3 Ашиглах норм, норматив
- 3.4 Мэдээллийн давтамж
- 3.5 Мэдээллийн эх үүсвэр

Дөрөв. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, шалгуур үзүүлэлт

- 4.1 Хүнсний хангамж
 - 4.1.1 Хүнсний хангамж, улсын түвшинд
 - 4.1.2 Хүнсний хүртээмж, өрхийн түвшинд
- 4.2 Хүнсний илчлэг, шим тэжээл
- 4.3 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал

Тав. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 оны 7 дугаар сарын 15-нд, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-нд УИХ-аар баталсан нь манай улс хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалтын шинэ орчинг бий болгосон. Уг үзэл баримтлал болон хуульд хүнсний аюулгүй байдлын тухай ойлголт, тодорхойлолтыг оруулсан.

Манай улсын хувьд хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүй, хүнсний аюулгүй байдлын түвшинг бодитоор тогтоож, үнэн зөв тооцож, тодорхойлж чадахгүй байгаагаас одоо байгаа статистикийн мэдээлэл нийгмийн эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого чиглэлийг боловсруулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хангалтгүй байна.

Иймд шинэчилсэн болон шинээр батлагдсан хоёр хуульд нийцүүлэн хүнсний аюулгүй байдлын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог сайжруулах, тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах, статистикийн зарим нэг үзүүлэлтийн эх үүсвэрт дүн шинжилгээ хийх, үнэн зөв мэдээллийг гаргах, хэрэглэгчдэд тархаах шаардлага гарч байна.

Түүнчлэн НҮБ-ын ХХААБ-аас хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг талаарх мэдээллийг ХАА-н тооллого, Өрхийн орлого, зарлагын судалгаа зэрэг статистикийн тооллого, судалгаагаар дамжуулан цуглуулж, улс, орон нутаг, өрхийн түвшинд шаардлагатай үзүүлэлтүүдийг тооцон, хүнсний хангамж, хүртээмж, илчлэг, шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд үнэлгээ, дүгнэлт өгөхийг улс орнуудад зөвлөмж болгосон байдаг.

Эдгээрт үндэслэн хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсрууллаа.

Энэхүү аргачлалыг хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцож, мэдээллийн нэгдсэн санг сайжруулахад мөрдлөг болгоно.

Хоёр. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт

Хүнсний аюулгүй байдал нь 1) Хүнсний хангамж 2) Хүнсний илчлэг, шим тэжээл, 3) Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

Энэ аргачлалд оруулсан нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

Хүнсний аюулгүй байдал гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг;

Хүнсний хангамж гэж чанарын шаардлага хангасан дотоодын үйлдвэрийн болон импортын хүнс улсын түвшинд хангалттай тоо хэмжээгээр бэлтгэгдсэн байхыг;

Хүнсний нийт нөөц гэж тухайн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, цэвэр импортын нийлбэрийг;

Цэвэр экспорт гэж импорт, экспортын зөрүүг;

Хүнсний хэрэгцээ гэж бодисын үндсэн солилцоо, бие мах бодийн эрхтэн тогтолцооны хэвийн үйл ажиллагаа, эд эсийн нөхөн төлжилт, илч зарцуулалтыг бүрэн нөхөхөд шаардагдах илчлэг болон шимт бодисын хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний хэмжээг;

Жишсэн хүн ам гэж насны бүлэг тус бүрийн хүний тоог шилжүүлэх итгэлцүүр ашиглан ижил түвшний дундаж хүнд шилжүүлэн тооцсон хүн амыг;

Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ гэж бодисын үндсэн солилцоо, бие мах бодийн эрхтэн тогтолцооны хэвийн үйл ажиллагаа, эд эсийн нөхөн төлжилт, илч зарцуулалтыг нөхөхөд нэг хоногт шаардагдах илчлэг, шимт бодисуудын хэмжээ, тэдгээрийг хангах хүнсний бүтээгдэхүүний хэмжээг;

Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ гэж жишсэн хүний хоногийн хэрэгцээг (зөвлөмж хэмжээг) 365 хоногоор үржүүлсэнтэй тэнцүү хэмжээг;

Жишсэн хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ гэж тухайн жилийн жишсэн хүн амын тоо, жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээний үржвэрийг;

Хүнсний хангамжийн хувь гэж улсын хэмжээний тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулж тодорхойлсныг;

Хүнсний хүртээмж гэж шаардлага хангасан шим тэжээлттэй хоол, хүнсээр хувь хүн хангагдах боломжийг;

Хүнсний хэрэглээ гэж илчлэг, шим тэжээллэг, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглэсэн хэмжээг;

Илчлэг, шим тэжээл гэж бие махбодын өсөн төлжих болон бодисын солилцоонд чухал үүрэгтэй хүнс, хоолны найрлагад агуулагддаг шимт бодисын бүрдлийг;

Илчлэг гэж усны уурыг цельсийн 1 хэмээр халаахад ялгарах дулааныг; (1 гр уураг, тос, нүүрс ус хүний биед задрахад ялгарах дулааныг) ;

Шимт бодис гэж хоол, хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах уураг, өөх тос, нүүрс ус, төрөл бүрийн аминдэм болон эрдэс бодисыг;

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангахыг;

Хүнсний эрүүл ахуй гэж хүнсийг тарьж ургуулах, үйлдвэрлэх, боловсруулахаас эхлээд хувь хүн хэрэглэх хүртэлх бүх үе шатанд хүнсний аюулгүй байдал, найдвартай баталгаатай байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай бүхий л арга хэмжээг;

Хүнсний сүлжээ гэж гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;

Өрхийн нийт орлого нь өрхийн гишүүдийн мөнгөн ба мөнгөн бус орлогын нийлбэрийг; мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний, хөрөнгө, мал борлуулсны орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хувьцааны ашиг, бусдаас авсан мөнгөн авлага зэргийн нийлбэр, мөнгөн бус орлого нь бусдаас үнэгүй авч хэрэглэсэн, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн зэрэг биетээр хэрэглэсэн зүйлийг мөнгөөр илэрхийлсэн дүнгийн нийлбэрээс бүрдэнэ.

Өрхийн хүнсний зарлага гэж өрхийн хүнсний хэрэгцээгээ хангахад зориулан зарцуулсан нийт мөнгөн зарлагын дүнг;

Гурав. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох бүтээгдэхүүн, ашиглах ангилал, норм, итгэлцүүр, мэдээллийг гаргах давтамж, мэдээллийн эх үүсвэр

3.1. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох хүнсний бүтээгдэхүүн

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцоходоо монгол хүн эрүүл аж төрөхийн тулд хоногт шаардагдах илчлэг, шим бодисын хэрэгцээг хангахад зайлшгүй чухал шаардлагатай дараах 13 бүлэгт хамаарах гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, ундны усыг хамруулна. Үүнд: мах, махан бүтээгдэхүүн; сүү; сүүн бүтээгдэхүүн; гурил; гурилан бүтээгдэхүүн; будаа; саахар, чихрийн зүйл; төмс; хүнсний ногоо; буурцагт ургамал; жимс; өндөг; хүнсний тос, ундны ус;

- 1. Мах, махан бүтээгдэхүүн:** таван хошуу малын мах, загас, шувуу, гахайн мах, зэрлэг ан амьтдын мах, чанамал болон чанамал, утлагат хиам, түүхий утлага хиам, дотор мах, нөөшилсөн мах, нөөшилсөн загасны мах, борц;
- 2. Сүү:** шингэн, хуурай сүү (25 хувийн тослогтой), өтгөрүүлсэн сүү;
- 3. Сүүн бүтээгдэхүүн:** тараг, кефир, йогурт, аарц (9 хувийн тостой), цөцгий, зөөхий (25 хувийн тостой), бяслаг, цөцгийн тос (72 хувийн тостой), ааруул, айраг, хоормог, шар тос, өрөм, эзгий ;
- 4. Гурил:** буудайн гурил, хөх тарианы гурил, бусад тарианы гурил;
- 5. Гурилан бүтээгдэхүүн:** бүх төрлийн талх, чанамал гурилан бүтээгдэхүүн, жигнэмэл гурилан бүтээгдэхүүн, жигнэмэг, өрмөнцөр, бялуун бүтээгдэхүүн, гоймон;
- 6. Төрөл бүрийн будаа:** цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа, бусад будаа;
- 7. Саахар, чихрийн зүйл:** элсэн чихэр, ёотон, хатуу чихэр, шоколад, зөөлөн чихэр, зефир, жимсний чанамал, сироп, хийжүүлсэн, хийжүүлээгүй ундаа ;
- 8. Төмс:** шинэ төмс, шарсан савханцар төмс, чипс, төмсний нухаш (усанд найруулж хэрэглэхэд бэлэн болгосон), төмсний цардуул, пүнтүүз;
- 9. Хүнсний ногоо:** үндсэн үрт ногоо (шар лууван, цагаан лууван, улаан лууван, хүрэн, шар, сармаг манжин, тонх, гич, үндэс үр яншуй, үндэс үрт цоор, үндэс үрийн гич), сонгинолог булцуу үүсгэдэг ногоо (бөөрөнхий сонгино, тагар сонгино, урт сонгино, порей сонгино, сармис гэх мэт), үр жимст ногоо (лооль, цэс, чинжүү, өргөст хэмх, хулуу, амтат гуа, тарвас), навчит ногоо (навчит байцаа, хятад байцаа, бууцай, навчит салат, хүнхээл, жууцай гэх мэт), цэцэгт ногоо (цэцэгт байцаа, броккли, артишок гэх мэт), толгой үүсгэдэг ногоо (бөөрөнхий байцаа, савайн байцаа, олон толгойт байцаа, бөөрөнхий салат), үнэрт ба амтлагч ногоо(гоньд, яншуй, цоохор майлз, үсүү, цоор), нөөшилсөн ногоо, хөлдөөсөн ногоо, хатаасан ногоо, мөөг, кетчуп, лоолийн шүүс, мөөг, нөөшилсөн мөөг;
- 10. Жимс, жимсгэнэ:** үрт жимс (алим, лийр, долоолгоно, тэс, ирга, гадир, хеномелес, кавказ илжгэн чих гэх мэт), яст жимс (интоор, чинтоор, тоор, гүйлс, шинэ чавга, туйван гэх мэт), байгалийн (зэрлэг) болон таримал (чацаргана, гүзээлгэнэ, үхрийн нүд гэх мэт) жимс, цитрусын төрлийн жимс (амтат жүрж, бэрсүүт жүрж, нимбэг гэх мэт), бусад жимс, хатаасан жимс, жимсгэнэ, нөөшилсөн жимс, жимсгэнэ, жимсний шүүс, сок, компот;
- 11. Буурцагт ургамал:** вандуй, шош, дүүпүү, нөөшилсөн вандуй;
- 12. Өндөг:** тахианы шинэ өндөг, бусад шувууны өндөг, хуурай өндөг;

13. **Хүнсний тос:** ургамлын тос, цэцгийн тос, өөхөн тос, маргарин, шар тос;

14. **Ундны ус:** савласан ундны ус

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох хүнсний бүтээгдэхүүнийг сонгохдоо “Стратегийн нөөцийн бараа, материалын нэр төрөл батлах тухай” УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 09 өдрийн 30 дугаар тогтоолоор стратегийн бүтээгдэхүүнд оруулахаар заасан гурил, төрөл бүрийн будаа, элсэн чихэр, ёотон, малын мах, нөөшилсөн махнаас гадна мөн тухайн салбарынхаа үйлдвэрлэл болон улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг, хүн амын хэрэглээ болон үйлдвэрлэлд чухал ач холбогдолтой, гадаад худалдааны экспорт, импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг бүтээгдэхүүн зэргийг харгалзан үзнэ.

3.2. Ашиглах ангилал

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцохдоо дараах 3 төрлийн ангиллыг ашиглана. Үүнд:

3.3.1 Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал (ХЗХБҮА)

3.3.2 Бараа, үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА)

3.3.3 Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)

3.3. Ашиглах норм, итгэлцүүр

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцохдоо дараах норм, итгэлцүүрийг ашиглана (Хавсралт 1). Үүнд:

3.3.1 Жишсэн хүн амд шилжүүлэх итгэлцүүр

3.3.2 Жишсэн нэг хүний хоногийн, жилийн хүнсний хэрэгцээний норм

3.3.3 Жишсэн нэг хүний хоногийн хүнснээс авах илчлэгийн хэрэгцээний норм

3.3.4 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох итгэлцүүр

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох итгэлцүүр, хүн амыг жишсэн хүн амд шилжүүлэх итгэлцүүр, жишсэн нэг хүний хоног, жилийн хүнсний хэрэгцээний норм, жишсэн нэг хүний хоногийн хүнснээс авах илчлэгийн хэрэгцээний норм зэргийг Хүнс, хөдөө аж ахуйн болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 5 жил тутамд шинэчлэн батлах бөгөөд эдгээрийг шинэчлэгдэн батлагдаж, хүчин төгөлдөр болсон тухай бүр хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцоход шууд ашиглана.

3.4. Мэдээллийн давтамж, хариуцан гаргах байгууллага

✓ Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг жилд нэг удаа, жилийн эцсийн байдлаар гаргана.

- Хүнсний хангамж, илчлэг, шим тэжээлийн үзүүлэлтийг Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүнсний хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Стандартчлал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хариуцан гаргана.

✓ Хүнс, хөдөө аж ахуйн болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүнсний хяналтын болон Стандартчлал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны нь өөрсдөд холбогдох хүнсний аюулгүй байдлын статистикийн

үзүүлэлтүүдийг 1 дүгээр сарын 20-ны дотор гарган статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

- ✓ Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг нэгтгэн гаргаж 5 дугаар сарын 1-ны дотор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлнэ.

3.5. Мэдээллийн эх үүсвэр

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох мэдээллийн эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлнэ. Үүнд:

3.5.1 Хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтүүд:

- *Улсын түвшинд хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцоход:*
 - Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээлэл /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
 - Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн жилийн мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
 - Гадаад худалдааны статистик мэдээлэл /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- *Өрхийн түвшинд хүнсний хүртээмжийн статистикийн үзүүлэлтийг тооцоход:*
 - Өрхийн нийгэм, эдийн засгийн улирлын түүвэр судалгааны үр дүн /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/

3.5.2 Хүнсний илчлэг, шим тэжээлийг тодорхойлох статистикийн үзүүлэлтүүд:

- Өрхийн нийгэм, эдийн засгийн улирлын түүвэр судалгааны үр дүн, /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/

3.5.3 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд:

- Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиргааны статистик мэдээлэл /Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд байгууллагаас гаргах захиргааны статистик мэдээлэл /Хүнсний хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд байгууллагаас гаргах захиргааны статистик мэдээлэл /Стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/

Дөрөв. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, шалгуур үзүүлэлт

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт болох хүнсний хангамж; хүнсний илчлэг, шим тэжээл; хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт тооцох арга зүй, шалгуур үзүүлэлтийг тус бүрд нь авч үзье.

4.1. Хүнсний хангамж

Хүнсний хангамжийг тооцох арга зүй. Хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтийг улсын түвшинд хүнсний хангамж, өрхийн түвшинд хүнсний хүртээмж гэсэн хоёр хэлбэрээр тооцно.

4.1.1 Хүнсний хангамж, улсын түвшинд. Хүнсний хангамжийг улсын түвшинд биет хэмжээгээр дараах үе шатаар тооцно. Үүнд:

1. Жишсэн хүн амын тоог тодорхойлно. Хүн амын жилийн хүнсний хэрэгцээг гаргахад жишсэн хүн амын тоог тодорхойлсон байна. Жишсэн хүн амын тоог гаргахдаа нас, хүйсээр өгөгдсөн тухайн оны хүн амын тоог жишсэн хүн амд шилжүүлэх насны ангиллын дагуу бүлэглэсэн итгэлцүүр (Хавсралт 1-ийн хүснэгт 1)-ээр үржүүлэн, бүлэг тус бүрийн дүнг нэмж тооцно.

Жишсэн хүн амын тоог дараах томъёогоор тооцно.

Үүнд:

$$XA_{\text{жиш}} = \sum(K_a * XA_a) \quad (1)$$

$XA_{\text{жиш}}$ - тухайн жилийн жишсэн хүн амын тоо

K_a - а насны бүлгийн хүн амыг жишсэн хүн амд шилжүүлэх итгэлцүүр

XA_a - а насны бүлгийн хүн амын тоо

2. Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг тооцно.

Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээг жишсэн хүн амын тоогоор үржүүлэн жилийн хэрэгцээг тооцно. Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$ЖХУ_{\text{жиш}} = ЖХ1_{\text{жиш}} * XA_{\text{жиш}} \quad (2)$$

$ЖХУ_{\text{жиш}}$ - Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ

$ЖХ1_{\text{жиш}}$ - Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ

$XA_{\text{жиш}}$ - Тухайн жилийн жишсэн хүн амын тоо

3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт, импортын мэдээг биет хэмжээгээр бэлтгэж, хэрэглэсэн нөөцийг тооцно. Хэрэглэсэн нөөц нь тухайн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл дээр цэвэр экспортыг нэмсэнтэй тэнцүү байна. Цэвэр экспорт нь импорт, экспортын зөрүүгээр тодорхойлогдоно. Хэрэглэсэн нөөцийг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$H_o = ДУ + (И - Э) \quad (3)$$

H_o - Нөөц

ДУ - Дотоодын үйлдвэрлэл

И - Импорт

Э - Экспорт

Хүнсний хэрэглэсэн нөөцийг хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн дагуу гаргана.

4. Хүнсний хангамжийн хувийг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр, биет хэмжээгээр тооцно. Хүнсний хангамжийг тооцохдоо нөөцийг жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээнд харьцуулж, 100-аар үржүүлэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн дагуу гаргана. Үүнийг томъёогоор харуулбал:

$$ХХ_{\text{хувь}} = \frac{H_o}{ЖХ_{\text{жиш}}} * 100$$

$ЖХ_{\text{жиш}}$ - Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ

H_o - Нөөц

$ХХ_{\text{хувь}}$ - Хүнсний хангамжийн хувь

5. Дотоодын үйлдвэрлэл, цэвэр экспортыг тус бүрд нь нийт хэрэгцээнд харьцуулж тухайн жилийн дотоодын үйлдвэрлэл, импортоор хангагдаж байгаа хувийг тодорхойлно.

4.1.1.1 Хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтийг улсын түвшинд тооцох мэдээллийн эх үүсвэр:

• Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн үзүүлэлтийг тооцоход дараах мэдээллийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн
 - Мал аж ахуйн бүтээгдэхүүний тооцоо, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
 - Аж үйлдвэрийн мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
 - Гадаад худалдааны мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Будаа, саахар, чихрийн зүйл, буурцагт ургамал
 - Гадаад худалдааны мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний мэдээ
 - Ургац хураалтын эцсийн мэдээ, /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
 - Гадаад худалдааны мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Өндөг
 - Тэжээвэр амьтдаас авч ашигласан бүтээгдэхүүний мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Хүнсний тос
 - Аж үйлдвэрийн мэдээ, өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
 - Гадаад худалдааны мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/

• Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг тооцоход дараах мэдээллийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Тухайн жилийн хүн амын тоо, нас, хүйсээр:
 - Суурин хүн амын мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр
 - Тогтоосон норм, хүн амын нас хүйсээр
- Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ
 - Тогтоосон норм, 13 гол нэрийн бүтээгдэхүүн, ундны ус
- Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ, нормоор
 - Тогтоосон норм, 13 гол нэрийн бүтээгдэхүүн, ундны ус

4.1.1.2 Хүнсний хангамжийн шалгуур үзүүлэлт: Хүнсний хангамжийг улсын түвшинд дараах шалгуураар тодорхойлно. Үүнд:

- Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас дээш хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан бол хүнсний хангамж тогтвортой хангагдаж байна гэж, харин дотоодын үйлдвэрлэлээр хангасан хүнсний хангамжийн хувь 70-аас доош хувиар байвал хүнсний хангамж тогтвортой байна гэж үзнэ.
- Гадаадын аль нэг орноос импортлох гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ нь гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импортын нийт дүнгийн 30 хувиас хэтрэхгүй бол хүнсний хангамж хараат бус буюу тэнцвэртэй байна гэж, хэтэрсэн тохиолдолд хүнсний хангамжийн тэнцвэрт байдал алдагдах буюу хараат байдалд орсон гэж үзнэ.

Жич: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан шалгуур үзүүлэлт

4.1.2 Хүнсний хүртээмж, өрхийн түвшинд

Хүнсний хүртээмжийг өрхийн хүнсний хэрэглээ, хүнсний дутагдал, хүнсний дутагдалд орох айдас, хүнсний дутагдалд орж буй шалтгаан зэрэг багц үзүүлэлтүүдээр тодорхойлно. Өрхийн хүнсний хүртээмжийг дараах алхмын дагуу, сэрүүн, зуны улирлаар, хот, хөдөөгөөр тооцно. Үүнд:

1. Өрхийн жишсэн нэг хүнд ногдох хоногийн хүнсний хэрэглээг тооцож, нормтой харьцуулна.

- 1.1 Судалгаанд хамрагдсан нийт өрхийн түвшинд сарын хүнсний хэрэглээ болон нийт жишсэн хүний тоог тодорхойлно.
- 1.2 Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэргийг хавсралтад өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан сүү, мах, гурил, саахар зэрэг жишсэн бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцно.
- 1.3 Судалгаанд хамрагдсан нийт өрхийн хүнсний хэрэглээг нийт жишсэн хүний тоонд хувааж, жишсэн нэг хүний сарын хэрэглээг тодорхойлно.
- 1.4 Жишсэн нэг хүнд ногдох сарын хүнсний хэрэглээг 30 хоногт хувааж, жишсэн нэг хүнд ногдох хоногийн хүнсний хэрэглээг тооцно.
- 1.5 Судалгаагаар тогтоогдсон жишсэн хүнд ногдох хоногийн хүнсний хэрэглээг жишсэн нэг хүний хоногийн хүнснээс авбал зохих нормд харьцуулна.

Жишсэн нэг хүний хэрэглэх норм, бодит хэрэглээний зөрүүг биет хэмжээгээр болон хувиар илэрхийлнэ.

2. Өрхийн зарлагад хүнсний зарлагын эзлэх хувийг өрхийн сарын хүнсний зарлагын хэмжээг орлогын хэмжээнд хувааж, 100-гаар үржүүлж тооцох бөгөөд хот, хөдөө, улсын түвшнээр гаргана.

3. Өрхийн нийт зарлагад гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувийг гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний сарын зарлагыг хэмжээг, өрхийн сарын орлогын хэмжээнд хувааж, 100-гаар үржүүлж тооцох бөгөөд үр дүнг хот, хөдөө, улсын түвшнээр гаргана.

4. Хүнсэндээ ихэвчлэн хэрэглэж буй бүтээгдэхүүний нэр төрөл: Хүнсэндээ ихэвчлэн хэрэглэж буй бүтээгдэхүүний нэр төрлийг мах, сүү, гурил 13 бүтээгдэхүүний нэр төрлөөр тодорхойлно. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд тооцож гаргана.

5. Хүнсэндээ хэрэглэсэн бүтээгдэхүүний хэмжээ: Судалгаанд хамрагдсан өрхийн хүнсний хэрэгцээндээ зарцуулсан гол бүтээгдэхүүний хэмжээгээр, өдөр, сар, жилээр тодорхойлно. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд тооцно.

6. Хүнсний бүтээгдэхүүний өдөрт хэрэглэх давтамж: Хүнсний бүтээгдэхүүний өдөрт хэрэглэх давтамжийг өдөрт хэрэглэсэн тоогоор илэрхийлнэ. Энэ үзүүлэлтийг өрхөд суурилсан тусгайлсан судалгааны дүнгээр, хот, хөдөө, улсын түвшинд тооцно.

7. Хүнсний дутагдалд ихэвчлэн ордог сар: Энэхүү үзүүлэлтийг өрхөд суурилсан тусгайлсан судалгаагаар тодорхойлох бөгөөд өрхөд ихэвчлэн аль сар бусад сарынхтай харьцуулахад хоол, хүнсний дутагдалтай байдаг вэ? гэсэн асуултаар тодорхойлно. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд нэгтгэн гаргана.

8. Хоол, хүнс дутагдалтай байхад нөлөөлсөн хүчин зүйлс: Уг үзүүлэлтийг өрхөд суурилсан тусгайлсан судалгааны дүнд үндэслэн өрхийн хоол, хүнсний дутагдалд орсон голлох хүчин зүйл тодорхойлно. Тухайлбал, ургац алдсан, ажил олдоогүй, өвдсөн, гэмтсэн, тахир дутуу болсон, өндөр настай болсон зэрэг шалтгаанаар ажиллах боломжгүй байсан; түүнчлэн газар, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин техникийн дутагдал, өрхийн ам бүлийн тоо хэтэрхий олон байгаа зэрэг үзүүлэлтээр тодорхойлох бөгөөд нийт өрхөд эдгээр хариултаас сонгож хариулсан өрхийн эзлэх хувиар илэрхийлнэ. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд нэгтгэж гаргана.

9. Хоол, хүнсний дутагдалд орохоос сэргийлэх, гарахын тулд тухайн өрхийн зүгээс хийсэн алхмууд: Уг үзүүлэлт нь хоол хүнс худалдаж авахын тулд хадгаламжаа ашигласан, зээл авсан, мал, газраа худалдсан, өөр ажилд орсон, өрхийн бизнесээ өргөжүүлсэн, хамаатан садан, бусад хүмүүс, засгийн газар, буяны болон олон улсын байгууллагын зүгээс туслалцаа авсан зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлох бөгөөд судалгаанд хамрагдсан нийт өрхөд эдгээр үзүүлэлтийг сонгон хариулсан өрхийн эзлэх хувиар илэрхийлнэ. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд нэгтгэж гаргана.

10. Жилийн туршид хүнсний дутагдалд орно гэсэн айдастай өрх: Уг үзүүлэлтийг байгалийн гамшигт өртсөн, ургац алдсан, ажилгүй болсон зэргээс шалтгаалж тухайн өрх нь тодорхой хугацаанд хоол хүнсний дутагдалд орно гэсэн айдастай байсан гэж хариулсан өрхийн тоогоор, тухайн өрхийн өөрсдийн хувийн үнэлгээн дээр үндэслэн тодорхойлно. Судалгаанд хамрагдсан нийт өрхөд уг үзүүлэлтэд хариулсан өрхийн эзлэх хувиар тодорхойлно. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд нэгтгэж гаргана.

11. Хүнсний дутагдалд ороход нөлөөлсөн байгалийн гамшгийн төрөл: Уг үзүүлэлт нь өрхийг хүнсний дутагдалд оруулсан шалтгаан, тухайлбал, үер ус, ган зуд, хүчтэй салхи шуурга, аянга, газар хөдлөлт зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлс зэргээр тодорхойлно. Судалгаанд хамрагдсан нийт өрхөд дээрх хүчин зүйлээс сонгож хариулсан өрхийн эзлэх хувиар тооцно. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд тодорхойлно.

12. Байгалийн гамшгаас болж алдсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээ: Уг үзүүлэлт нь байгалийн гамшгийн нөлөөгөөр алдсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлно. Учруулсан хохирлыг хэмжээгээр нь бага, дунд, их гэж ангилна. Хохирлын хэмжээг үнэлэхдээ байгалийн гамшиг тохиолдоогүй хэвийн байсан жилийн бүтээгдэхүүний хэмжээг гамшиг тохиолдсон жилийн бүтээгдэхүүний хэмжээнд харьцуулж гаргах бөгөөд бүтээгдэхүүний харьцаа 10.0-20.0 хувиас доогуур байвал бага, 20.0-30.0 хувьтай тэнцүү бол дунд, 30.0 хувиас дээш байвал их гэж үзнэ. Уг үзүүлэлтийг хот, хөдөө, улсын түвшинд тодорхойлно.

4.1.2.1 Хүнсний хүртээмжийн статистикийн үзүүлэлтийг өрхийн түвшинд тооцох мэдээллийн эх үүсвэр

Хүнсний хүртээмжийн статистикийн үзүүлэлтийг тооцоход дараах мэдээллийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Жишсэн нэг хүний хоногийн бодит хэрэглээ
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/

4.1.2.2 Хүнсний хүртээмжийн шалгуур үзүүлэлт. Өрхийн хүнсний хүртээмжийг дараах шалгуураар тодорхойлно. Үүнд:

- Судалгааны үр дүнгээр, бодитойгоор гарсан жишсэн нэг хүнд ногдох хүнсний хоногийн хэрэглээг жишсэн нэг хүний хоногийн хэрэгцээний нормтой харьцуулахад уг *нормоос бага гарвал өрхийн хүнсний хүртээмж хангалтгүй буюу хүнсний дутагдалтай, нормтой харьцуулахад тэнцүү буюу их байвал өрхийн хүнсний хүртээмж хангалттай* байна гэж үзнэ.

4.2. Хүнсний илчлэг, шим тэжээл

Хүнсний илчлэг, шим тэжээлийг тооцох арга зүй. Хоол хүнс нь үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодис болон бичил тэжээлийн бодисуудаас бүрдэнэ. Үндсэн шимт бодис гэдэгт уураг, тос, нүүрс, ус хамаарна.

Хүнснээс авах илчлэг, шим тэжээлийг килокалороор (ккал) хэмжинэ.

Нүүрс, ус нь цагаан будаа, гоймон, талх зэрэг үр тарианы гаралтай бүтээгдэхүүнд илүү агуулагддаг бөгөөд 1 граммд ногдох илчлэгийн хэмжээ нь 4 ккал байна.

Тос нь мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногоо, самар, загас, наранцэцэг, хулуу зэрэг бүтээгдэхүүнд агуулагддаг бөгөөд 1 граммд ногдох илчлэгийн хэмжээ нь 9 ккал байна.

Уураг нь мах, дүүпүү, шар буурцаг, өндөг, үр тариа, цагаан идээ, сүү, бяслаг зэрэг бүтээгдэхүүнд агуулагдах бөгөөд 1 граммд ногдох илчлэгийн хэмжээ нь 4 ккал байна.

Хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийг сэрүүн, зуны улирлаар тодорхойлоход дараах нормыг ашиглана (Хавсралт 1-ын хүснэгт 3, 4).

Хүнсний илчлэг, шим тэжээлийн үзүүлэлтийг дараах дарааллаар тооцно. Үүнд:

1. Өрхийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг тооцно. Өрхийн хүнсний хэрэглээ бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр, биет хэмжээгээр тооцно.
2. Бүтээгдэхүүнийг ижил төрлийн бүтээгдэхүүнд шилжүүлнэ. Мах, махан бүтээгдэхүүн (лаазалсан мах, хиам зэрэг), сүү, сүүн бүтээгдэхүүн (ааруул, эззгий зэрэг), гурил, гурилан бүтээгдэхүүн (нарийн боов, жигнэмэг, гоймон зэрэг) зэргийг хавсралт 1-ийн хүснэгт 5-16-д өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан сүү, мах, гурил, саахар зэрэг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцно.
3. Өрхийн гишүүдийг жишсэн хүнд шилжүүлнэ. Өрхийн гишүүдийг нас, хүйсээр ялгаж, жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүрийг ашиглаж, жишсэн хүнд шилжүүлнэ.
4. Нэг хүнд ногдох хэрэглээг бүтээгдэхүүний төрлөөр гаргана. Бүтээгдэхүүн тус бүрээр тооцсон, судалгаанд хамрагдсан өрхийн хүнсний хэрэглээ болон өрхийн жишсэн хүний тооны нийлбэрийг нийт жишсэн хүний тоонд хувааж, жишсэн нэг хүнд ногдох хоногийн хэрэглээг, бүтээгдэхүүн тус бүрээр гаргана.
5. Жишсэн хүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, шим тэжээлийг тооцно. Жишсэн нэг хүний хоногийн хэрэглээг хүнсний илчлэг, шим тэжээлийн хэрэгцээний нормоор, нэг хүний хоногт хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийг тооцно.

Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, найрлагыг улсын дундаж, хот, хөдөөгөөр, сэрүүн, зуны улирлаар ангилж гаргана.

4.2.1 Хүнсний илчлэг шим, тэжээлийн үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр:

- Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэглээ
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/

4.2.2 Хүнсний илчлэг, шим тэжээлийн шалгуур үзүүлэлт

Хүнсний илчлэг, шим тэжээлийн шалгуур үзүүлэлтийг дараах шалгуураар тодорхойлно.

- Судалгааны үр дүнгээр, бодитойгоор гарсан жишсэн нэг хүний хоногт хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийн хэмжээг, жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах ёстой илчлэг, шим тэжээлийн нормтой харьцуулахад *90 хувиас бага байвал хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн бодисуудыг хангалттай авч чадахгүй, 90-109 хувь байвал физиологийн нормийн түвшинд, 110 хувиас их байвал хэтрүүлсэн* гэж үзнэ.

4.3 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдэд хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин; улсын хэмжээнд бүртгэгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн тоо; импортын болон дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс буцаасан, хураасан, устгасан бүтээгдэхүүний тоо хэмжээ; эрүүл ахуй, үйлдвэрлэл, стандартын хяналтын талаархи мэдээлэл, мөрдөгдөж буй хүнсний бүтээгдэхүүний стандартчилалын тоо; олон улсад мөрдөгдөж буй хүнсний бүтээгдэхүүний стандартчилалаас Монгол Улсад нэвтрүүлсэн стандартчилалын тоо; дотоодын чанарын стандартчилал мөрдөж буй үйлдвэрийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг багтаана.

4.3.1 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тодорхойлох статистикийн үзүүлэлтүүд

1. Хяналт шалгалтаар, итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин- Хяналт шалгалтаар, итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын хувиар илэрхийлнэ. Уг үзүүлэлтийг хими, нян судлал, хүнд металл, хор судлал, ургамал хорио цээр, цацрагийн шинжилгээгээр, гол нэрийн 13 төрлийн хүнсний бүтээгдэхүүн болон ундны усаар гаргана.

2. Хураасан, буцаасан, татан авсан, дахин боловсруулсан, устгасан импортын болон дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ: Дээрх тоо хэмжээ нь импортын болон дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнээс тайлант хугацаанд хяналт, шалгалтад хамрагдаж, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй буцаасан, хураасан, татан авсан, дахин боловсруулсан, устгасан бүтээгдэхүүний нийлбэрээр тодорхойлно. Уг үзүүлэлт нь 13 гол нэрийн бүтээгдэхүүн болон ундны усаар гарна. Импорт болон дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний тоо хэмжээг тус тусад нь гаргана.

3. Хяналт, шалгалтад хамрагдсан ба үйл ажиллагааг нь түр зогсоосон, үйл ажиллагааг нь сэргээсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн: Тайлант хугацаанд хяналт, шалгалтад хамрагдсан, үйл ажиллагааг түр зогсоосон, сэргээсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тоогоор тодорхойлно. Уг үзүүлэлтийг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн төрөл, хэлбэрээр нэгтгэнэ. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч гэдэгт иргэн, хуулийн этгээд, анхан шатны үйл ажиллагаа эрхлэхээс эхлээд хүнсний сүлжээний бүх үе шат хамрагдана.

4. Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн болон арилгуулсан зөрчлөөр тус тусад нь гаргана. Энэхүү үзүүлэлтийг дараах төрлөөр авч үзнэ. Үүнд:

- Үйлдвэрлэл, үйлчилгээний байршил, барилга байгууламжийн норм дүрмийг зөрчсөн зөрчил
- Ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн эрүүл ахуйн нөхцөлтэй холбоотой зөрчил
- Технологи үйл ажиллагаатай холбоотой зөрчил

- Ажиллагчдын ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой зөрчил
- Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалтай холбоотой зөрчил
- Бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой зөрчил
- Бүтээгдэхүүний савлагаа, хаяг, шошгоны холбоотой зөрчил сав, баглаа боодол, хаяг шошголохтой холбоотой зөрчил
- Дотоодын хяналтын үйл ажиллагаатай холбоотой зөрчил

5. Хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторийн тоо: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарын болон аюулгүйн үзүүлэлтээр Үндэсний MNS/ISO 17025 стандартын дагуу эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус өмчит хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг лабораторийн тоогоор тодорхойлно.

6. Хүнсний холбогдолтой үндэсний, олон улс, бүс нутаг, гадаад орны стандарт болон техникийн зохицуулалтын тоо: Монгол улсын хэмжээнд хүнсний салбарт мөрдөгдөж байгаа бүтээгдэхүүний техникийн шаардлагын, шинжилгээний аргын, нэр томъёоны болон суурь стандартууд болох Үндэсний MNS, CAS, гадаад орны стандартын тооны нийлбэрээр тодорхойлно.

7. Тохирлын үнэлгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн тоо: Эрх бүхий байгууллагаас бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалт, холбогдох норм, норматив баримт бичигт заасан үзүүлэлт, шаардлагад тохирч байгааг баримт бичгээр нотолж гэрчилгээ, тэмдэг олгосон бүтээгдэхүүний тооны нийлбэрээр тодорхойлно.

8. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо: Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг хангах байдлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас үнэлж, гэрчилгээ олгосон үйлдвэрийн тооны нийлбэрээр тодорхойлно.

9. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо: Зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг эрх бүхий байгууллагаас үнэлж, гэрчилгээ олгосон үйлдвэрийн тооны нийлбэрээр тодорхойлно.

10. Баяжуулсан хүнс үйлдвэрлэдэг үйлдвэрийн тоо, үйл ажиллагааны төрлөөр, баяжуулсан хүнсний хувийн жин, бүтээгдэхүүний төрлөөр - Гурил, давс зэрэг баяжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрийн тоогоор, хүн амыг шимт бодисын дутлаас хамгаалах зорилгоор нэмэлт бодисоор баяжуулсан гурил, давс зэрэг бүтээгдэхүүний тухайн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн дүнд эзлэх хувийн жингээр тус тусад нь тодорхойлно.

11. Баталгаат ундны усаар хангагдаж буй хүн амын тоо - ундны усаа баталгаат ус түгээх газар, ус түгээх тусгайлсан машин, техникээр хангаж буй хүн амын тоогоор илэрхийлнэ.

12. Архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэрийн тоо, 10000 хүн ам тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо - Архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуй, нэгж байгууллагын тооны нийлбэрээр, согтууруулах ундаа зарж борлуулах зөвшөөрөлтэй худалдааны цэгийн тоо, хүн амын тооны харьцааг 10000-аар үржүүлснээр тооцно.

13. Нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ тухайн жилд үйлдвэрлэсэн болон импортолсон архи, дарс, шар айраг, спиртэн бүтээгдэхүүний хэмжээ, нийт хүн ам,

насанд хүрсэн хүн амын тооны харьцаагаар илэрхийлнэ. Насанд хүрсэн хүн амыг 15-аас дээш насны хүн амын тоогоор гарна.

14. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо, өвчилсөн хүний тоо, үүнээс эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, нас барсан хүний тоо - Нянгийн болон химийн бодисын гаралтай хоолны хордлого, халдварын тохиолдлын нийлбэрээр, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоогоор тооцож гаргана.

4.3.2 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр:

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн 1-4 дүгээр үзүүлэлтүүд
 - Захиргааны статистик мэдээлэл / Хүнсний хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн 5-9 дүгээр үзүүлэлтүүд
 - Захиргааны статистик мэдээлэл /Стандарчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн 10, 12 дугаар үзүүлэлтүүд
 - Захиргааны статистик мэдээлэл /Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн 11, 13 дугаар үзүүлэлтүүд
 - Хүн ам, өрхийн мэдээллийн сан, аж үйлдвэрийн мэдээ /Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн 14 дүгээр үзүүлэлт
 - Захиргааны статистикийн мэдээлэл /Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/

4.3.3 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг дараах шалгуураар тодорхойлно.

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тодорхойлох эерэг үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 60-80 хувь нь нэмэгдсэн, сөрөг үзүүлэлтүүдийн 60-80 хувь нь буурсан тохиолдолд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдаж байна гэж, харин эерэг үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 40-60 хувь нь нэмэгдсэн, сөрөг үзүүлэлтүүдийн 40-60 хувь нь буурсан тохиолдолд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд эерэг хандлагатай гэж үзнэ. Мөн хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тодорхойлох эерэг үзүүлэлтүүд нь 20-40 хувиар нэмэгдсэн, сөрөг үзүүлэлтүүд нь 20-40 хувиар буурсан тохиолдолд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд сөрөг хандлагатай байна гэж үзнэ. Харин хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тодорхойлох эерэг үзүүлэлтүүд нь 20 ба түүнээс доош хувиар нэмэгдсэн, сөрөг үзүүлэлтүүд нь 20 ба түүнээс доош хувиар буурсан тохиолдолд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдахгүй байна гэж үзнэ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын эерэг үзүүлэлтэд 5-11 дүгээр үзүүлэлтүүдийг, сөрөг үзүүлэлтэд 1-4, 12-14 дугаар үзүүлэлтүүдийг хамруулна.

Тав. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийн мэдээллийн сан

Хүнсний хангамжийн аюулгүй байдал дохио, шалгуур өгөхөд шаардлагатай үндсэн болон бусад үзүүлэлтүүдээр хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийн мэдээллийн санг үүсгэж, үүнд дараах мэдээллийг хамруулна.

5.1 Хүнсний аюулгүй байдлын статистикийн үндсэн үзүүлэлтүүд

- 5.1.1 Хүнсний хангамж, хүртээмжийн үзүүлэлт
- 5.1.2 Хүнсний илчлэг, шим тэжээлийн үзүүлэлт
- 5.1.3 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт
 - Хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин: Хүнсний бүтээгдэхүүний нянгийн болон химийн бохирдолтын түвшин
 - Буцаасан, хураасан, устгасан импортын бүтээгдэхүүний тоо хэмжээ
 - Хураасан, устгасан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ
 - Хяналт, шалгалтад хамрагдсан ААНБ, хувь хүний тоо
 - Хяналт, шалгалтаар үйл ажиллагааг нь бүр зогсоосон, түр зогсоосон, үйл ажиллагааг нь сэргээсэн байгууллага, иргэний тоо
 - Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн, арилгуулсан зөрчил: Дотоодын хүнсний үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын түвшин
 - Импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага хангалтын түвшин
 - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн байдал
 - Улсын хэмжээнд итгэмжлэгдсэн лабораторийн тоо
 - Монгол улсын хэмжээнд хүнсний салбарт мөрдөгдөж байгаа Үндэсний MNS, CAS, гадаад орны стандартын тоо,
 - Олон улс, бүс нутаг, гадаад орны стандартыг Үндэсний стандарт болгосон стандартын тоо
 - Тохирлын үнэлгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн тоо
 - Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас баталгаажуулалт авсан үйлдвэрийн тоо
 - Үйл ажиллагаандаа зохистой дадал, хяналт болон удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо
 - Баяжуулсан хүнсний хувийн жин, бүтээгдэхүүний төрлөөр
 - Баяжуулсан хүнс бэлтгэдэг үйлдвэрийн тоо, үйл ажиллагааны төрлөөр
 - Баталгаат ундны усаар хангагдаж буй хүн амын тоо
 - Архи, шар айраг, спиртийн үйлдвэрийн тоо
 - 10000 хүн амд тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо
 - Нэг хүнд ногдох архи, шар айраг, спиртын бүтээгдэхүүн, насанд хүрэгчид, нийт хүн амд ногдуулж бодсноор
 - Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо, өвчилсөн хүний тоо, үүнээс эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, амь насаа алдсан хүний тоо
- 5.1.4 Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг цэг
 - Хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо, төрлөөр
 - Хүнсний дэлгүүр, супермаркетын тоо
 - Хүнсний захын тоо
 - Хүнсний агуулах, зоорийн тоо, хүчин чадал, бүтээгдэхүүний төрлөөр
 - Цайны газар, гуанз, зоогийн газрын тоо
 - Цэвэр ус, ундаа, архи, пиво, спиртийн үйлдвэрийн тоо
 - 10000 хүн амд тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо
- 5.1.5 Хүнсстэй холбоотой эрүүл мэндийн мэдээлэл
 - Хоол хүнсээр дамжих өвчнөөр өвчилсөн хүний тоо, хот, хөдөөгөөр
 - Хоол, хүнсстэй холбоотой бусад өвчлөлийн мэдээлэл

- Байх ёстой жингээс доогуур жинтэй 5 ба түүнээс доош насны хүүхдийн тоо, хүйсээр, хот, хөдөөгөөр
- Нянгийн гаралтай хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдварын өвчлөлөөр өвчилсөн хүний тоо, хот, хөдөөгөөр
- Химийн гаралтай хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдварын өвчлөлөөр өвчилсөн хүний тоо, хот, хөдөөгөөр
- Хоол, хүнсээр дамжих өвчний улмаас хордлого, халдварын өвчлөлөөр өвдөж, амь насаа алдсан хүний тоо, хот, хөдөөгөөр

5.2 Хүнсний аюулгүй байдлыг тодорхойлох бусад үзүүлэлтүүд

5.2.1 Хөдөө аж ахуй

- Малын тоо, төрлөөр
- Хээлтэгч малын тоо, төрлөөр
- Хүнсэнд хэрэглэсэн малын тоо, төрлөөр
- Мах үйлдвэрлэл
- Сүү үйлдвэрлэл
- ХАА-н эдэлбэр газрын хэмжээ, га-гаар
- Тариалсан талбай, ургамлын төрлөөр
- Хураасан талбай, ургамлын төрлөөр
- Хураасан ургац, ургамлын төрлөөр
- Га-гийн ургац, ургамлын төрлөөр
- Жишсэн хүн амын гурилын хэрэгцээ, үүнийг хангахад шаардлагатай үр тариа, тариалсан талбайн хэмжээ, тооцоогоор

5.2.2 ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл

- Мал аж ахуй
- Газар тариалан

5.2.3 ХАА-н нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь

- Мал аж ахуй
- Газар тариалан

5.2.4 Аж үйлдвэр

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, биет хэмжээгээр
- Архи, шар айраг, спиртийн үйлдвэрлэл, биет хэмжээгээр
- Нэг хүнд ногдох архи, шар айраг, спиртэн бүтээгдэхүүн, биет хэмжээгээр, нийт хүн ам, насанд хүрэгчдэд ногдуулснаар
- Ундны усны үйлдвэрлэл, биет хэмжээгээр

5.2.5 Гадаад худалдаа

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импорт, биет хэмжээгээр, улс, орноор
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, биет хэмжээгээр, улс, орноор
- Савласан ундны усны импорт, биет хэмжээгээр, улс, орноор

5.2.6 Үнэ

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импортын үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспортын үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний бөөний үнийн мэдээ

5.2.7 Хүн амын тоо

- Суурин хүн амын тоо, нас, хүйсээр

5.2.8 Ажиллагчдын тоо

- Ажиллагчдын тоо, салбараар
- Мал аж ахуйд ажиллагчдын тоо

- Газар тариаланд ажиллагчдын тоо
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо

5.2.9 Ундны ус

- Ундны ус түгээх цэгийн тоо
- Ус тээврийн автомашины тоо
- Баталгаат усан хангамжаар хангагдсан хүн амын тоо
- Төвлөрсөн усан хангамжийн нян, химийн бохирдолтын түвшин
- Төвлөрсөн бус усан хангамжийн нян, химийн бохирдолтын түвшин

5.2.10 Үйлдвэрлэлийн мэдээ, үйлдвэрлэлийн төрлөөр, гол нэрийн бүтээгдэхүүний нэр төрлөөр

- Үйлдвэрийн тоо
- Үйлдвэрлэлийн тоо хэмжээ
- Үйлдвэрлэлийн хүчин чадал / ашиглалт
- Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
- Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал

5.2.11 Савласан ус, согтууруулах ба согтруулах бус ундааны үйлдвэрлэл, гол нэрийн бүтээгдэхүүний нэр төрлөөр

- Үйлдвэрийн тоо
- Үйлдвэрлэлийн тоо хэмжээ
- Үйлдвэрлэлийн хүчин чадал / ашиглалт
- Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
- Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал

5.2.12 Хүнсний худалдаа эрхлэлтийн байдал, төрлөөр

- Тоо хэмжээ
- Үндсэн хүчин чадал
- Ашиглагдаж буй хүчин чадал
- Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
- Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал

5.2.13 Гол нэр төрлийн хүнсний 13 бүтээгдэхүүн болон савласан усны гадаад худалдааны мэдээ, гаалийн бүрдүүлэлт хийсэн газар, хороодоор

- Тоо хэмжээ
- Үнийн дүнгээр, ам доллараар

5.2.14 Ундаа, согтууруулах ундааны гадаад худалдааны мэдээ, гаалийн бүрдүүлэлт хийсэн газар, хороодоор:

- Тоо хэмжээ
- Үнийн дүнгээр, ам доллараар

5.2.15 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний гадаад худалдаа, тээвэрлэлтийн төрлөөр, нэр төрлөөр

- Тоо хэмжээ
- Үнийн дүнгээр, ам доллараар

5.2.16 Гол нэр төрлийн хүнсний 13 бүтээгдэхүүн болон савласан усны гадаад худалдааны үеийн хүнсний бүтээгдэхүүний хадгалалт

- Тоо хэмжээ
- Үнийн дүнгээр, ам доллараар

5.2.17 Нийтийн хоолны үйлдвэрлэл, төрлөөр

- Тоо хэмжээ
- Үндсэн хүчин чадал

- Ашиглагдаж буй хүчин чадал
- Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
- Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал

5.2.18 Хүнсний тусламжийн талаарх мэдээ, хандивлагч улсаар, бараагаар:

- Хүнсний нэр төрөл
- Хандивлагч улсын нэр
- Тоо хэмжээ
- Үнийн дүнгээр, ам доллараар

ЭХЗАГВАР

Хүснэгт 1. Жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр

Насны бүлэг	Хүйс	Мөрийн дугаар	Шилжүүлэх итгэлцүүр
А	Б	В	1
1 хүртэлх насны	эм, эр	1	0.38
1-3 насны	эм	3	0.48
	эр	4	0.50
4-6 насны	эм	5	0.64
	эр	6	0.68
7-10 насны	эм	7	0.72
	эр	8	0.87
11-14 насны	эм	9	0.74
	эр	10	0.96
15-18 насны	эм	11	0.87
	эр	12	1.05
19-24 насны	эм	13	0.82
	эр	14	1.04
25-50 насны	эм	15	0.78
	эр	16	0.99
51 ба түүнээс дээш насны	эм	17	0.72
	эр	18	0.81

Хүснэгт 2. Жишсэн нэг хүний хоногийн болон жилийн хүнсний хэрэгцээний норм, биет хэмжээгээр

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Мөрийн дугаар	Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ, кг	Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ, кг
А	Б	1	2
Мах, махан бүтээгдэхүүн	1	0.200	73.0
Сүү	2	0.150	54.8
Сүүн бүтээгдэхүүн	3	0.200	73.0
Гурил	4	0.100	36.5
Гурилан бүтээгдэхүүн	5	0.220	80.3
Төрөл бүрийн будаа	6	0.078	28.5
Саахар, чихрийн зүйл	7	0.023	8.4
Төмс	8	0.140	51.1
Хүнсний ногоо	9	0.200	73.0
Жимс, жимсгэнэ	10	0.180	65.7
Буурцагт ургамал	11	0.090	32.9
Өндөг	12	0.019	6.9
Хүнсний тос	13	0.025	9.1

**Хүснэгт 3. Жишсэн нэг хүний хоногийн хүнсний
илчлэгийн норм, зуны улиралд**

А	Б	Жишсэн нэг хүний хоол хүнснээс хоногт авах илчлэг, ккал*	Шимт бодисууд, (гр)						Нүүрс ус
			Уураг	Үүнээс:		Тос	Үүнээс:		
				Амьтны	Ургамлын		Амьтны	Ургамлын	
		1	2	3	4	5	6	7	8
Мах, махан бүтээгдэхүүн	1	281	28	28	0	19	19	0	0
Сүү	2	160	10	10	0	9	9	0	10
Сүүн бүтээгдэхүүн	3	166	8	8	0	9	9	0	12
Гурил	4	325	9	0	9	1	0	1	70
Гурилан бүтээгдэхүүн	5	452	12	0	12	2	0	2	95
Төрөл бүрийн будаа	6	269	9	0	9	0	0	0	57
Саахар, чихрийн зүйл	7	92	0	0	0	0	0	0	23
Төмс	8	123	3	0	3	0	0	0	28
Хүнсний ногоо	9	28	2	0	2	0	0	0	5
Жимс, жимсгэнэ	10	265	17	0	17	2	0	2	45
Буурцагт ургамал	11	84	1	0	1	0	0	0	20
Өндөг	12	30	2	2	0	2	2	0	0
Хүнсний тос	13	225	0	0	0	25	0	25	0
Бүгд	14	2500	101	48	53	69	39	30	365

**Хүснэгт 4. Жишсэн нэг хүний хоногийн хүнсний
илчлэгийн норм, сэрүүний улиралд**

А	Б	Жишсэн нэг хүний хоол хүнснээс хоногт авах илчлэг, ккал	Шимт бодисууд, (гр)						Нүүрс ус
			Уураг	Үүнээс:		Тос	Үүнээс:		
				Амьтны	Ургамлын		Амьтны	Ургамлын	
		1	2	3	4	5	6	7	8
Мах, махан бүтээгдэхүүн	1	374	38	38	0	25	25	0	0
Сүү	2	120	7	7	0	7	7	0	7
Сүүн бүтээгдэхүүн	3	113	6	6	0	6	6	0	8
Гурил	4	325	9	0	9	1	0	1	70
Гурилан бүтээгдэхүүн	5	452	12	0	12	2	0	2	95
Төрөл бүрийн будаа	6	269	9	0	9	0	0	0	57
Саахар, чихрийн зүйл	7	92	0	0	0	0	0	0	23
Төмс	8	123	3	0	3	0	0	0	28
Хүнсний ногоо	9	28	2	0	2	0	0	0	5
Жимс, жимсгэнэ	10	265	17	0	17	2	0	2	45
Буурцагт ургамал	11	84	1	0	1	0	0	0	20
Өндөг	12	30	2	2	0	2	2	0	0
Хүнсний тос	13	225	0	0	0	25	0	25	0
Бүгд	14	2500	106	53	53	70	40	30	358

**ГОЛ НЭРИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ НЭГ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖҮҮЛЭН
ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР**

Хүснэгт 5. Мах, махан бүтээгдэхүүнийг тураг маханд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
1.1	Таван хошуу малын мах	1.0
1.2	Гахай, шувуу болон загасны мах	1.0
1.3	Ангийн мах (зэрлэг ан амьтдын мах)	1.0
1.4	Чанамал хиам	1.1
1.5	Чанамал, утлагат хиам	1.4
1.6	Түүхий утлагат хиам	2.6
1.7	Дотор мах	1.4
1.8	Махан консерв	1.3
1.9	Борц	5.7
1.10	Загасны консерв	1.57

Хүснэгт 6. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг шингэн сүүнд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
2.1. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн:		
2.1.1.	Ундны сүү *	1.0
2.1.2	Хуурай сүү (25%-ийн тостой)	8.6
2.1.3	Өтгөрүүлсэн сүү	2.7
2.1.4	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн* (тараг, кефир, йогурт, г.м)	1.0
2.1.5	Аарц (9%-ийн тостой)	6.7
2.1.6	Цөцгий, зөөхий (25%-ийн тостой)	7.8
2.1.7	Бяслаг	8.8
2.1.8	Цөцгийн тос (72%-ийн тостой)	22.5
2.1.9	Ааруул	10.0
2.2. Уламжлалт аргаар үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүн:		
2.2.1	Исэг цагаан идээ (тараг, айраг, хоормог)	1.0
2.2.2	Шар тос	25.0
2.2.3	Өрөм	16.7
2.2.4	Эззгий	13.0

Тайлбар: * - түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний тос агууламж 1:1 байна.

Хүснэгт 7. Гурил, гурилан бүтээгдэхүүнийг гурилд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
3.1	Буудайн гурил	1.0
3.2	Хөх тарианы гурил	1.0
3.3	Бусад тарианы гурил	1.0
3.4	Бүх төрлийн талх	0.74
3.5	Чанамал гурилан бүтээгдэхүүн	0.65
3.6	Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн	0.60
3.7	Жигнэмэг	0.60
3.8	Өрмөнцөр	0.25
3.9	Бялуун бүтээгдэхүүн	0.15
3.10	Гоймон	1.0

Хүснэгт 8. Төрөл бүрийн будааг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
4.1	Цагаан будаа	1.0
4.2	Гурвалжин будаа	1.0
4.3	Шар будаа	1.0
4.4	Бусад будаа	1.0

Хүснэгт 9. Саахар, чихрийн зүйлийг саахарт шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
5.1	Элсэн чихэр	1.0
5.2	Ёотон	1.0
5.3	Хатуу чихэр	0.96
5.4	Шоколад. зөөлөн чихэр. зефир	0.46
5.5	Жимсний чанамал. сироп	0.46
5.6	Хийжүүлсэн. хийжүүлээгүй ундаа	0.47

**Хүснэгт 10. Төмс, төмсний төрлийн бүтээгдэхүүнийг
шинэ төмсөнд шилжүүлэх итгэлцүүр**

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
6.1	Шинэ төмс	1.0
6.2	Шарсан савханцар төмс (French fries)	2.0
6.3	Чипс	4.0
6.4	Төмсний нухаш (усанд найруулж хэрэглэхэд бэлэн болгосон)	8.5
6.5	Төмсний цардуул, пүнтүүз	10.0

Хүснэгт 11. Хүнсний ногоог шинэ ногоонд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
7.1	Үндэс үрт ногоо (шар лууван, цагаан лууван, улаан лууван, хүрэн, шар, сармаг манжин, тонх, гич, үндэс үрт яншуй, үндэс үрт цоор, үндэс үрийн гич)	1.0
7.2	Сонгинолог булцуу үүсгэдэг ногоо (бөөрөнхий сонгино, тагар сонгино, урт сонгино, порей сонгино, сармис, гэх мэт)	1.0
7.3	Үр жимст ногоо (лооль, цэс, чинжүү, өргөст хэмх, хулуу, амтат гуа, тарвас)	1.0
7.4	Навчит ногоо (навчит байцаа, хятад байцаа, бууцай, навчит салат, хүнхээл, жууцай гэх мэт)	1.0
7.5	Цэцэгт ногоо (цэцэгт байцаа, брокколи, артишок гэх мэт)	1.0
7.6	Толгой үүсгэдэг: Бөөрөнхий байцаа, савайн байцаа, олон толгойт байцаа, бөөрөнхий салат	1.0
7.7	Үнэрт ба амтлагч ногоо: гоньд, яншуй, цоохор майлз, үсүү, цоор	1.0
7.8	Нөөшилсөн ногоо	1.3
7.9	Хөлдөөсөн ногоо	1.3
7.10	Хатаасан ногоо, мөөг	9.0
7.11	Кетчуп	2.48
7.12	Лоолийн шүүс	1.64
7.13	Мөөг	1.0
7.14	Нөөшилсөн мөөг	1.25

Хүснэгт 12. Жимс, жимсгэнийг шинэ жимсэнд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
8.1	Үрт жимс (алим, лийр, долоогоно, тэс, ирга, гадир, хеномелес, кавказ, илжгэн чих гэх мэт)	1.0
8.2	Яст жимс (интоор, чинтоор, тоор, гүйлс, шинэ чавга, туйван гэх мэт)	1.0
8.3	Байгалийн (зэрлэг) болон таримал (чацаргана, гүзээлзгэнэ, үхэр нүд гэх мэт)	1.0
8.4	Цитрусын төрлийн жимс (амтат жүрж, бэрсүүт жүрж, нимбэг гэх мэт)	1.0
8.5	Бусад жимс	1.0
8.6	Хатаасан жимс, жимсгэнэ	3.23-5.0
8.7	Нөөшилсөн жимс, жимсгэнэ	0.85
8.8	Жимсний шүүс, сок	0.7
8.9	Компот	0.68

Хүснэгт 13. Буурцагт ургамлыг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
9.1	Вандуй, шош, шар буурцаг	1.0
9.2	Дүүпүү	0.6
9.3	Нөөшилсөн вандуй, шош	1.3

Хүснэгт 14. Өндөг, өндөгний бүтээгдэхүүнийг шинэ өндөгнд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
10.1	Тахианы шинэ өндөг	1.0
10.2	Бусад шувууны өндөг	1.0
10.3	Хуурай өндөг	24.84

Хүснэгт 15. Хүнсний тосыг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэх итгэлцүүр

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
11.1	Ургамлын гаралтай тос	1.0
11.2	Цөцгийн тос	1.0
11.3	Өөхөн тос	1.0
11.4	Маргарин	0.8
11.5	Шар тос	1.2